



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/54/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум

2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер : Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: [oyunsuvdts@audit.gov.mn](mailto:oyunsuvdts@audit.gov.mn)

Гэрээт аудитор : Ц.Алтантуул

Утас: 91195554

Цахим хаяг: [tuul9565@gmail.com](mailto:tuul9565@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	16

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.23 № 112

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЗАВХАН АЙМГИЙН ОНЦГОЙ  
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА  
Ө.БОЛД-Д

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Завхан аймгийн Онцгой байдлын газар нь урсгал үйл ажиллагаанаас 3,625.8 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 381.7 сая төгрөгийн, нийт 4,007.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, зарцуулсан байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 265.6 сая төгрөгийн материал бэлтгэж, 278.2 сая төгрөгийн материал шилжүүлэн авч, 707.6 сая төгрөгийн материалыг зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Завхан аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар шагнал, урамшуулал зэрэгцүүлэн олгосон, хавсран ажилласны нэмэгдлийг илүү олгосон, шатахууны тооцоо буруу бодсон зэрэг зөрчил илэрсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Бараа материалын хөдөлгөөний бүртгэлийг буруу хийсэн, хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн байна.

013020184

Audit(D)Дүгнэлт/2024

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,197,781,638.82</u></b>	<b><u>1,034,047,034.07</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,197,781,638.82	1,034,047,034.07
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	147,637,781.50	169,606,181.50
35110	Тусгай зориулалттай материал	143,299,531.50	167,069,531.50
35130	Эм боох материал	4,338,250.00	2,536,650.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	1,049,443,857.32	863,740,852.57
35410	Бичиг хэргийн материал	3,341,831.82	4,859,331.82
35420	Аж ахуйн материал	302,017,459.98	302,017,459.98
35430	Сэлбэг хэрэгсэл	32,821,708.00	47,640,804.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	28,387,553.40
35470	Бусад хангамжийн материал	711,262,857.52	480,835,703.37
35600	Мал амьтад	700,000.00	700,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>6,815,938,407.04</u></b>	<b><u>5,994,457,654.34</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	6,815,938,407.04	5,994,457,654.34
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	6,197,873,207.04	5,376,392,454.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,073,138,644.05	4,073,138,644.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	-916,438,028.88	-1,079,210,151.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,909,149,245.55	4,984,649,245.55
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-2,814,407,639.54
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	619,791,075.87	619,791,075.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	-526,935,858.99	-549,637,442.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	83,011,976.85	65,011,976.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	-62,767,993.48	-62,094,943.44
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	313,499,570.31	313,499,570.31
39212	Хуримтлагдсан элэгдэл	-128,210,295.98	-174,347,881.74
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	618,065,200.00	618,065,200.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,650,000.00	-1,650,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	618,065,200.00	618,065,200.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>8,013,720,045.86</u></b>	<b><u>7,028,504,688.41</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>8,013,720,045.86</u></b>	<b><u>7,004,417,135.01</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	8,013,720,045.86	7,004,417,135.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,125,452,567.37	1,125,452,567.37
51101	Өмч: - төрийн	1,125,452,567.37	1,125,452,567.37
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	6,241,151,941.88	5,231,849,031.03

51210	Өмнөх үеийн үр дүн	6,241,151,941.88	6,241,151,941.88
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,009,302,910.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	647,115,536.61	647,115,536.61
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>8,013,720,045.86</b>	<b>7,004,417,135.01</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,672,218,086.00</b>	<b>4,361,398,556.55</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>608,310,576.00</b>	<b>353,722,656.55</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	608,310,576.00	353,722,656.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	608,310,576.00	353,722,656.55
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	608,310,576.00	353,722,656.55
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,063,907,510.00</b>	<b>4,007,675,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,635,751,300.00	3,625,883,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,635,751,300.00	3,625,883,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	428,156,210.00	381,792,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,963,457.00	51,187,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	328,706,680.00	72,793,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	257,810,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,980,915,896.74</b>	<b>5,355,951,467.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,980,915,896.74</b>	<b>5,355,951,467.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,977,815,896.74	5,349,721,267.40
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,615,992,876.17	3,115,940,600.00
210101	Үндсэн цалин	1,061,080,400.00	1,515,739,200.00
210102	Нэмэгдэл	518,543,074.51	1,469,171,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,369,401.66	54,934,000.00
210104	Урамшуулал	00.00	76,096,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	54,558,800.00	113,364,300.00
210201	Тэтгэврийн даатгал	13,277,000.00	22,316,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,561,800.00	2,625,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,195,600.00	2,100,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	427,700.00	525,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,096,700.00	85,797,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	154,180,879.14	312,315,177.00
210301	Гэрэл, цахилгаан	15,014,212.79	31,832,050.26
210302	Түлш, халаалт	130,983,266.35	272,212,856.74
210303	Цэвэр, бохир ус	8,183,400.00	8,270,270.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	95,823,853.52	130,129,500.00

210401	Бичиг хэрэг	2,371,607.63	144,000.00
210402	Тээвэр, шатахуун	83,036,200.00	101,734,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,735,845.89	2,695,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,680,200.00	25,555,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>64,487,370.00</b>	<b>72,938,100.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	2,170,800.00
210502	Хоол, хүнс	64,487,370.00	70,767,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>166,269,606.00</b>	<b>148,839,136.00</b>
210604	Урсгал засвар	157,319,606.00	148,839,136.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>17,033,000.00</b>	<b>38,123,239.00</b>
210702	Дотоод албан томилолт	17,033,000.00	38,123,239.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,538,305.00</b>	<b>2,222,700.00</b>
210804	Тээврийн хэрэгслийн татвар	422,518.00	672,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	961,400.00	174,700.00
210807	Газрын төлбөр	649,587.00	1,375,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>805,931,206.91</b>	<b>1,415,848,515.40</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	114,700,886.75	533,617,762.70
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	686,798,820.16	882,230,752.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,100,000.00</b>	<b>6,230,200.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,100,000.00</b>	<b>6,230,200.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,100,000.00	6,230,200.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>691,302,189.26</b>	<b>-994,552,910.85</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>14,750,000.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	14,750,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-14,750,000.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>691,302,189.26</b>	<b>-1,009,302,910.85</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,164,211,300.00</b>	<b>4,007,675,900.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,164,141,300.00</b>	<b>4,007,675,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,115,949,300.00</b>	<b>3,625,883,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,115,949,300.00	3,625,883,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>48,192,000.00</b>	<b>381,792,300.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,966,000.00	51,187,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,052,000.00	72,793,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	257,810,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,101,128,993.30</b>	<b>4,007,675,900.00</b>

21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,101,128,993.30	4,007,675,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,098,337,764.20	4,001,445,700.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,607,330,376.17	3,115,940,600.00
210101	Үндсэн цалин	1,053,080,400.00	1,515,739,200.00
210102	Нэмэгдэл	517,880,574.51	1,469,171,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,369,401.66	54,934,000.00
210104	Урамшуулал	00.00	76,096,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,558,800.00	113,364,300.00
210201	Тэтгэврийн даатгал	13,277,000.00	22,316,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,561,800.00	2,625,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,195,600.00	2,100,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	427,700.00	525,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,096,700.00	85,797,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	146,480,349.14	292,815,000.00
210301	Гэрэл, цахилгаан	15,014,212.79	31,832,050.26
210302	Түлш, халаалт	124,396,516.35	252,712,679.74
210303	Цэвэр, бохир ус	7,069,620.00	8,270,270.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,825,617.89	8,985,500.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	5,734,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,334,917.89	2,695,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,680,200.00	555,900.00
2105	Нормативт зардал	56,822,950.00	70,559,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	369,200.00
210502	Хоол, хүнс	56,822,950.00	70,190,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	171,357,306.00	176,169,386.00
210604	Урсгал засвар	162,097,306.00	176,169,386.00
2107	Томилолт, зочны зардал	17,033,000.00	38,123,239.00
210702	Дотоод албан томилолт	17,033,000.00	38,123,239.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,933,305.00	2,222,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	422,518.00	672,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	356,400.00	174,700.00
210807	Газрын төлбөр	649,587.00	1,375,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,996,060.00	183,265,475.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,564,560.00	183,265,475.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,791,229.10	6,230,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,100,000.00	6,230,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,100,000.00	6,230,200.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	---

C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	507,387,367.37	69,867,845.27	2,257,553,257.47	2,834,808,470.11
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	507,387,367.37	69,867,845.27	2,257,553,257.47	2,834,808,470.11
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	5,199,849.70	5,199,849.70
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,125,452,567.37	647,115,536.61	6,241,151,941.88	8,013,720,045.86
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,125,452,567.37	647,115,536.61	6,241,151,941.88	8,013,720,045.86
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,125,452,567.37	647,115,536.61	6,241,151,941.88	8,013,720,045.86
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,009,302,910.85	-1,009,302,910.85
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,125,452,567.37	647,115,536.61	5,231,849,031.03	7,004,417,135.01

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,625,883,600.00	3,625,883,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,625,883,600.00	3,625,883,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,619,653,400.00	3,619,653,400.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,115,940,600.00	3,115,940,600.00
210101	Үндсэн цалин	1,515,739,200.00	1,515,739,200.00
210102	Нэмэгдэл	1,469,171,400.00	1,469,171,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,934,000.00	54,934,000.00
210104	Урамшуулал	76,096,000.00	76,096,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,364,300.00	113,364,300.00
210201	Тэтгэврийн даатгал	22,316,300.00	22,316,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,625,400.00	2,625,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,100,400.00	2,100,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	525,100.00	525,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	85,797,100.00	85,797,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	292,815,000.00	292,815,000.00
210301	Гэрэл, цахилгаан	14,353,300.00	31,832,050.26
210302	Түлш, халаалт	270,962,800.00	252,712,679.74

210303	Цэвэр, бохир ус	7,498,900.00	8,270,270.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,251,300.00</b>	<b>3,251,300.00</b>
210401	Бичиг хэрэг	972,800.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,783,300.00	2,695,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	495,200.00	555,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>70,559,500.00</b>	<b>70,559,500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	369,200.00	369,200.00
210502	Хоол, хүнс	70,190,300.00	70,190,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,500,000.00</b>	<b>15,500,000.00</b>
210604	Урсгал засвар	15,500,000.00	15,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,222,700.00</b>	<b>2,222,700.00</b>
210804	Тээврийн хэрэгслийн татвар	672,800.00	672,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	174,700.00	174,700.00
210807	Газрын төлбөр	1,375,200.00	1,375,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,000,000.00</b>	<b>6,000,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	6,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,230,200.00</b>	<b>6,230,200.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>6,230,200.00</b>	<b>6,230,200.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,230,200.00	6,230,200.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,625,883,600.00</b>	<b>3,625,883,600.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,625,883,600.00</b>	<b>3,625,883,600.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,625,883,600.00	3,625,883,600.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>156.00</b>	<b>154.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	151.00	149.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00

#### 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>381,792,300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>381,792,300.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>381,792,300.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,734,200.00</b>
210402	Тээвэр, шатахуун	5,734,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>160,669,386.00</b>
210604	Урсгал засвар	160,669,386.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>38,123,239.00</b>
210702	Дотоод албан томилолт	38,123,239.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>177,265,475.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	177,265,475.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>381,792,300.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>381,792,300.00</b>

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,187,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,793,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	257,810,800.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Онцгой байдлын газар нь “Онцгой байдлын албаны техник, багаж, тоног төхөөрөмж, хувцас хэрэгслэлийн чанар ашиглалтыг сайжруулах, гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэд технологийг нэвтрүүлж төрийн үйл ажиллагааг цахимжуулах” зорилтын хүрээнд үйл ажилалгаагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын зөвлөл нь 2023 оны ажлын төлөвлөгөөндөө 12 ажил хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт бүрд удирдамж батлуулж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,009,302.91 мянган төгрөгөөр буюу 12.5 хувиар буурсан байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	1,197,781.64	1,006,459.48	(191,322.16)
Үндсэн хөрөнгө	10,618,305.71	10,679,305.71	61,000.00
Нийт хөрөнгө	8,013,720.05	7,004,417.14	(1,009,302.91)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,013,720.05	7,004,417.14	(1,009,302.91)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,013,720.05	7,004,417.14	(1,009,302.91)

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Бараа материалын эхний үлдэгдэл 1,197,781.6 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 262,186.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, Онцгой байдлын Ерөнхий газар болон бусад газраас 278,222.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 731,731.7 мянган төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 1,006,459.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 191,322.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 3,500.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 75,500.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, 18,000.0 мянган төгрөгийн хөрөнгө шийдвэрийн дагуу шилжүүлж, жилийн эцэст 10,679,305.7 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 882,230.7 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 1,009,302.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

**5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,625,883.6 мянган төгрөг, нийт зарлагыг 3,625,883.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,625,883.6 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,625,883.6 мянган төгрөг буюу 100 хувьтай зарцуулсан байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөрсарга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>					
70708	Гамшгаас урьдчилан сэргийлэх				
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,625,883.6	3,625,883.6		100%
	<b>НИЙТ</b>	<b>3,625,883.6</b>	<b>3,625,883.6</b>		<b>100%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3. Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 381,792.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгал засварын зардалд 160,669.3 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 5,734,2 мянган төгрөг, гамшгийн томилолтын зардалд 38,123,3 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 177,265,4 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

### 4. Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 5. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Нээлттэй тендер шалгаруулалт	Улиастай сум богдын гол багт аврагч гудамж байгуулах материалын худалдан авалт	90,000.00	90,000.00
2	Тендер шалгаруулалтын онцгой журам	Хоол хүнсний материал худалдан авах	26,666.90	26,666.90
<b>ДҮН</b>			<b>116,666.90</b>	<b>116,666.90</b>

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Ари финайнс аудит” ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг “Ари финайнс аудит” ХХК-ийн захирал Д.Ариунаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер

Х.Болдбаатар нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари финайнс аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,980,915.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 44,713.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 33.535.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,355,951.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 80,339.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 75 хувиар буюу 60.254.4 мянган төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 29 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завхан аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **6. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд Онцгой байдлын ерөнхий газраас санхүүжүүлсэн шатахууны зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 48,588.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 588.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 48,000.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 48,588.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 11,666.0 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

#### **5.1 Төлбөрийн акт**

Хавсран ажилласны нэмэгдлийг 588,400 төгрөгөөр илүү тооцож, олгосонд төлбөрийн акт тогтоолоо.

**5.2 Байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан шатахууныг 48,000.0 мянган төгрөгийг бараа материалын тайланд буруу тусгаж, баримтын бүрдлийг ханган ажиллаагүйд албан шаардлага хүргүүлээ.**

5.3 Зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт				Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
	Үүнээс		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын тайлан буруу илэрхийлсэн	1	48,000.0			1	48,000.0						
Хавсран ажилласны нэмэгдэл илүү олгосон	1	588.4	1	588.4								
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>48,588.4</b>	<b>1</b>	<b>588.4</b>	<b>1</b>	<b>48,000.0</b>						

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]* Д.БАТ-УНДРАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

“АРИ ФИНАЙНС АУДИТ” ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР *[Signature]*

Х.БОЛДБААТАР

Ц.ОЮУНСУВД

Ц.АЛТАНТУУЛ

Огноо: 2024-02-22